САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2020 оны 06 сарын 10 өдөр Дугаар 347 Улаанбаатар хот

Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.4, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.3, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан "Даатгалын багц дүрэм"-ийн 01 дүгээр хавсралт "Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт"-ийн 3.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хавсралтад дурдсан "Хас баяжих" хадгаламж зээлийн хоршоонд "Миг даатгал" ХХК-ийн даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.

2. Тусгай зөвшөөрөл олгогдсон "Хас баяжих" ХЗХ-нд "Миг даатгал" ХХК-аас бусад даатгалын компанид даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэхгүй болохыг анхааруулсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны
2020 оны 36 дугаар сарын 10-ны өдрийн
311.7 дугаар тогтоолын хавсралт

ТУ32072 9020030255 5043239

Даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл олгох
“Хас баяжих” ХЗХ-ны товч мэдээлэл

№	Компанийн нэр	Регистрийн дугаар	Үйл ажиллагаа явуулах хүрээ	Хаяг, Утасны дугаар	Тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхлэх даатгалын хэлбэр
1	“Хас баяжих" Хадгаламж зээлийн хоршоо	3858235	Хоршооны гишүүд	Төв аймаг, Батсүмбэр сум, Мандал, 1-р баг Утас:86064876	Гэнэтийн осол, эмчилгээний, Хөрөнгийн, Автотээврийн хэрэгслийн, Ачааны, Барилга угсралтын, Газар тариалангийн, Мал амьтдын, Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын, Хариуцлагын, Санхүүгийн, Зээлийн, Итгэлцлийн, Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал